



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
 ᠭᠣᠪᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
 ЗАСАГ ДАРГЫН  
 ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/43

Алтай хот

**Тогтоолын хэрэгжилтийг хангуулах  
 тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, "Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын 5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор баталсан орон тооны хязгаарт багтаан чиг үүргийн шинжилгээг хийж, хэлтэс тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах агентлагийн хооронд чиг үүргийн давхардал, хийдэл үүсгэхгүйгээр оновчтой зохицуулалтыг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:Ц.Батзориг

Гишүүд:

Ц.Эрдэнэбат

П.Хулан

Л.Хаш-Эрдэнэ

Л.Отгончимэг

Х.Баатарзориг

Д.Төмөрбаатар

Ц.Мөнхзаяа

- (аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- (Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- (Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- (Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- (Цэргийн штабын дарга)
- (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

2.

- Б.Нандин-Эрдэнэ-(Төрийн үйлчилгээ-мэдээллийн төвийн мэргэжилтэн)  
П.Бат-Очир -(Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
Б.Золжаргал -(Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)  
Н.Пагмадулам -(Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)  
С.Мөнхжаргал -(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
Э.Буянтөгс -(Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)  
Г.Баасанцог -(Цэргийн штабын офицер)  
Д.Анхбаатар -(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)  
Р.Цэнд-Аюуш -(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)  
Л.Ариунтуяа -(Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
Д.Мөнхсүвд -(Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)  
Нарийн бичгийн дарга: Б.Итэшмаа -(Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)  
Э.Туул -(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн мэргэжилтэн)

2.Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр батлагдсан орон тооны хязгаарын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн ажлын байрны нэр, албан тушаалын чиг үүргийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд судалж, чанартай боловсруулж, ажлын үр дүнг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг (Ц.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц чиг үүргийг оновчтой тодорхойлж, зохион байгуулалтын өөрчлөлт орсон албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батзориг, Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Итэшмаад тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР